



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 8/134

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн “Захиалагчийн алба” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 7,193,609.10 (долоон сая нэг зуун ерэн гурван мянга зургаан зуун есөн төгрөг арван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн “Захиалагчийн алба” ОНӨААТҮГ (Д.Алтанхуяг)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 1,586,990.89 (нэг сая таван зуун наян зургаан мянга есөн зуун ерэн төгрөг наян есөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 14 нэр төрлийн 5,606,618.18 (тавин сая зургаан зуун зургаан мянга зургаан зуун арван найман төгрөг арван найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 80,000.00 (наян мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь 24,000.00 (хорин дөрвөн мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн Төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэн, Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн “Захиалагчийн алба” ОНӨААТҮГ (Д.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа

В.ОЮУМАА

1150500498

19	Сандаг Түшлэгтэй	4	ш	1	681,727.27	681,727.27	681,727.27	-	эвдэрсэн	актлах	5,000.00	устгах
	Тавилга, эд хогшлын дүн				681,727.27	681,727.27	681,727.27	-	-	-	5,000.00	-
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				7,193,609.1			6,511,881.8	-	-	53,000.0	80,000.0
	Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгийн дүн				5,606,618.2			5,606,618.2	-	-		
	Устгах хөрөнгө				1,586,990.9			905,263.6	-	-		
	Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн											
	Худалдан борлуулах дүн							80,000.00				
	Худалдсанаас олох орлого							56,000.00				
	НӨХГ-т төвлөрүүлэх /30%/							24,000.00				